



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БӨМБӨГӨР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/84/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням:

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт /эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



Г БӨМБӨГӨР СУМЫН ЕРӨНХИЙ 7
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.НАСАНТОГТОХ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021. 02.25 № 2/139

танай _____ -ны № _____ -г

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** 7

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага нь Сумын Засаг дарга, аймгийн Боловсрол, соёл урлагийн газартай гэрээ байгуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийг тооцон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

005020108

Аудитын гол асуудал

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Байгууллагын дарга тушаал гаргаагүй байхад 6707.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан;
- Кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайланг холбогдох журам, стандартын бэлтгэж гаргаагүй байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	95,783,547.56	128,850,221.24
33	АВЛАГА	10,000,000.00	9,950,000.00
335	Бусад авлага	10,000,000.00	9,950,000.00
3351	Байгууллагаас авах авлага	10,000,000.00	9,950,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,783,547.56	118,900,221.24
351	Түүхий эд материал	67,712,356.70	82,536,300.38
35110	Тусгай зориулалттай материал	67,712,356.70	82,536,300.38
354	Хангамжийн материал	18,071,190.86	36,363,920.86
35420	Аж ахуйн материал	15,685,840.86	25,276,520.86
35440	Түлш, шатах тослох материал	00.00	3,852,000.00
35460	Хүнсний материал	63,850.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	2,321,500.00	7,235,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,051,501,522.09	1,029,009,412.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,051,501,522.09	1,029,009,412.63
392	Биет хөрөнгө	1,017,127,522.09	994,635,412.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	926,965,873.78	948,665,873.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-34,175,477.40	-80,119,385.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,000,000.00	-6,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	116,950,352.10	125,648,208.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-86,554,116.60	-100,990,327.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	99,084,365.90	115,146,865.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,834,131.95	-56,913,181.60
39217	Ном	27,690,656.26	31,197,359.26
393	Биет бус хөрөнгө	34,374,000.00	34,374,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,374,000.00	34,374,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,147,285,069.65	1,157,859,633.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	73,442.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	73,442.00
413	Өглөг	00.00	73,442.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	73,442.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,147,285,069.65	1,157,786,191.87
51	Засгийн газрын хувь оролцоо	1,147,285,069.65	1,157,786,191.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	433,663,308.00	433,663,308.00
51101	Өмч: - төрийн	433,663,308.00	433,663,308.00
512	Хуримтлагдсан үр дүн	225,195,580.23	235,696,702.45
51210	Өмнөх үеийн үр дүн	225,195,580.23	225,195,580.23
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	10,501,122.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	488,426,181.42	488,426,181.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,147,285,069.65	1,157,859,633.87



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	700,348,741.00	867,910,958.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,523,441.00	42,340,386.13
120	Нийтлэг татварын бус орлого	15,523,441.00	42,340,386.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,523,441.00	42,340,386.13
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,523,441.00	42,340,386.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	684,825,300.00	792,281,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	643,961,100.00	745,864,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	643,961,100.00	745,864,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	33,288,672.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	33,288,672.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,864,200.00	46,417,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,864,200.00	46,417,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	689,248,811.44	857,409,835.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	689,248,811.44	857,409,835.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	661,676,235.44	783,926,860.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,104,000.10	554,000,214.70
210101	Үндсэн цалин	418,815,000.10	368,332,946.30
210102	Нэмэгдэл	27,934,700.00	87,160,558.91
210104	Урамшуулал	19,129,200.00	67,759,945.61
210105	Гэрээт ажлын хөлс	12,225,100.00	30,746,763.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,334,298.00	70,013,226.30
210201	Тэтгэврийн даатгал	45,160,000.00	46,946,826.30
210202	Тэтгэмжийн даатгал	5,381,598.00	5,696,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,746,800.00	4,557,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	913,100.00	1,420,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,132,800.00	11,392,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,833,218.00	38,315,846.00
210301	Гэрэл, цахилгаан	5,752,018.00	4,860,546.00
210302	Түлш, халаалт	30,975,200.00	33,230,400.00
210303	Цэвэр, бохир ус	106,000.00	224,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,836,300.00	9,875,390.00
210401	Бичиг хэрэг	2,401,200.00	1,616,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,234,500.00	4,683,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,934,800.00	1,290,000.00
210404	Ном, хэвлэл	431,000.00	25,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	105,000.00	795,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,729,800.00	1,466,000.00
2105	Нормативт зардал	14,862,475.00	11,685,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	541,100.00	256,400.00
210502	Хоол, хүнс	13,337,675.00	9,849,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	983,700.00	1,579,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,160,000.00	1,725,000.00
210604	Урсгал засвар	3,160,000.00	1,725,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,068,000.00	1,442,000.00
210702	Дотоод албан томилолт	2,068,000.00	1,442,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,192,000.00	10,450,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	792,000.00	10,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,285,944.34	86,419,783.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,056,778.11	11,242,015.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,414,500.00	2,718,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,814,666.23	72,459,168.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,572,576.00	73,482,975.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,011,200.00	43,340,572.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,059,200.00	14,328,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,727,072.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,561,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,952,000.00	5,723,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	982.00	10,354.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	982.00	10,354.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	560,394.00	30,132,049.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	560,394.00	30,132,049.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,099,929.56	10,501,122.22
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,418,751.12	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,418,751.12	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-12,418,751.12	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-1,318,821.56	10,501,122.22

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	684,825,300.00	825,570,572.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	684,825,300.00	825,570,572.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	643,961,100.00	745,864,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	643,961,100.00	745,864,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	33,288,672.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	33,288,672.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	40,864,200.00	46,417,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,864,200.00	46,417,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	684,825,300.00	801,830,110.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,825,300.00	801,830,110.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	657,252,724.00	728,347,135.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,980,356.00	545,439,099.00
210101	Үндсэн цалин	337,448,556.00	344,393,027.47
210102	Нэмэгдэл	70,789,300.00	93,572,841.91
210104	Урамшуулал	39,395,500.00	72,349,465.74
210105	Гэрээт ажлын хөлс	31,347,000.00	35,123,763.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,425,700.00	78,500,900.00
210201	Тэтгэврийн даатгал	45,160,000.00	55,715,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,566,600.00	5,696,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,653,200.00	4,557,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	913,100.00	1,139,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,132,800.00	11,392,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,363,218.00	43,406,846.00
210301	Гэрэл, цахилгаан	3,753,218.00	3,953,246.00

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210302	Түлш, халаалт	29,510,000.00	38,353,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	1,100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,339,400.00	12,987,790.00
210401	Бичиг хэрэг	2,272,200.00	2,392,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,704,200.00	4,099,990.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,645,800.00	1,730,000.00
210404	Ном, хэвлэл	2,717,400.00	1,726,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	1,010,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,819,800.00	2,028,300.00
2105	Нормативт зардал	14,701,250.00	13,658,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	541,100.00	1,841,100.00
210502	Хоол, хүнс	13,066,450.00	9,785,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,093,700.00	2,031,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,750,000.00	9,846,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	6,450,000.00
210602	Тавилга	12,250,000.00	725,000.00
210604	Урсгал засвар	16,500,000.00	2,671,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,068,000.00	1,442,000.00
210702	Дотоод албан томилолт	2,068,000.00	1,442,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,192,000.00	1,824,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	792,000.00	1,374,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,432,800.00	21,241,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,700,000.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,732,800.00	16,241,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,572,576.00	73,482,975.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,011,200.00	43,340,572.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,059,200.00	14,328,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	14,727,072.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	8,561,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,952,000.00	5,723,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	982.00	10,354.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	982.00	10,354.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	560,394.00	30,132,049.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	560,394.00	30,132,049.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	23,740,462.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	23,740,462.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	23,740,462.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	23,740,462.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	23,740,462.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-23,740,462.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	229,649,855.75	1,151,739,345.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	229,649,855.75	1,151,739,345.17
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,318,821.56	-1,318,821.56
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	225,195,580.23	1,147,285,069.65
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	225,195,580.23	1,147,285,069.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	225,195,580.23	1,147,285,069.65
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,501,122.22	10,501,122.22
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	235,696,702.45	1,157,786,191.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	793,281,900.00	762,139,497.00	-31,142,403.00	96.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	793,281,900.00	762,139,497.00	-31,142,403.00	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	761,262,400.00	742,087,597.00	-19,174,803.00	97.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,033,700.00	545,439,099.00	-14,594,601.00	97.4
210101	Үндсэн цалин	347,669,200.00	344,393,027.47	-3,276,172.53	99.1
210102	Нэмэгдэл	98,803,700.00	93,572,841.91	-5,230,858.09	94.7
210104	Урамшуулал	75,447,100.00	72,349,465.74	-3,097,634.26	95.9
210105	Гэрээт ажлын хөлс	38,113,700.00	35,123,763.88	-2,989,936.12	92.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,500,900.00	78,500,900.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	55,715,300.00	55,715,300.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,696,300.00	5,696,300.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,557,200.00	4,557,200.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,139,300.00	1,139,300.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,392,800.00	11,392,800.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,417,200.00	43,406,846.00	-10,354.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,954,200.00	3,953,246.00	-954.00	100.0
210302	Түлш, халаалт	38,363,000.00	38,353,600.00	-9,400.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	1,100,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,697,500.00	13,678,452.00	-19,048.00	99.9

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	2,392,900.00	2,392,900.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	4,100,000.00	4,099,990.00	-10.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,808,600.00	1,730,000.00	-78,600.00	95.7
210404	Ном, хэвлэл	2,416,700.00	2,416,662.00	-38.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	951,000.00	1,010,600.00	59,600.00	106.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,028,300.00	2,028,300.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	17,515,800.00	13,658,600.00	-3,857,200.00	78.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,841,100.00	1,841,100.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	13,643,100.00	9,785,900.00	-3,857,200.00	71.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,031,600.00	2,031,600.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,096,200.00	21,096,200.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,150,000.00	7,150,000.00	0.00	100.0
210602	Тавилга	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	6,446,200.00	6,446,200.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,115,700.00	1,442,000.00	-673,700.00	68.2
210702	Дотоод албан томилолт	2,115,700.00	1,442,000.00	-673,700.00	68.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,824,000.00	1,824,000.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,374,000.00	1,374,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23061400.00	23041500.00	-19,900.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,061,400.00	18,041,500.00	-19,900.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32019500.00	20051900.00	-11,967,600.00	62.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,019,500.00	20,051,900.00	-11,967,600.00	62.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,294,300.00	14,328,900.00	-11,965,400.00	54.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,725,200.00	5,723,000.00	-2,200.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	793,281,900.00	762,139,497.00	-31,142,403.00	96.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	745,864,700.00	715,732,651.00	-30,132,049.00	96.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	745,864,700.00	715,732,651.00	-30,132,049.00	96.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,417,200.00	46,406,846.00	-10,354.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	46,417,200.00	46,406,846.00	-10,354.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	00.00	-1,000,000.00	0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	00.00	-1,000,000.00	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	50.00	50.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	18.00	18.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	33,288,672.00	33,288,672.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	33,288,672.00	33,288,672.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	10,000,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	10,000,000.00	10,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	10,000,000.00	10,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0	23,288,672.00	23,288,672.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	23,288,672.00	23,288,672.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	14,727,072.00	14,727,072.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0	8,561,600.00	8,561,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	23,288,672.00	23,288,672.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	23,288,672.00	23,288,672.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	23,288,672.00	23,288,672.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Бөмбөгөр сумын ЕБС-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Л.Насантогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэхгүй байх, эд хөрөнгийн тооллогын үр дүнг байгууллагын даргын тушаалаар баталгаажуулж байх, хөрөнгө акталсан тухай бүрд устгал хийсэн баримтыг санхүүгийн баримтад хавсаргах, төрийн аудитын байгууллагад баримтыг бүрэн ирүүлж байх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Бөмбөгөр сумын ЕБС 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.01.25-ний өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага “Эх хэлээрээ зөв сайхан бичдэг, бусдыг хүндэлдэг, хөдөлгөөний эвсэлтэй хамт олон болгох” эрхэм зорилго тавьж ажилласан байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд тайланд онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Зорилт нэг. Боловсролын удирдлага, менежментийг сайжруулах чиглэлээр:

1.1 Сургалтын чанарт ахиц гаргах мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжсэн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2 Бага боловсролын хамран сургалтыг 99.5 хувьд, суурь боловсролыг 95 хувьд тус тус хүргэж ажиллана.

1.3 Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, давтан бэлтгэх, чанаржуулах бодлогыг барьж 2021 оны аймгийн үндсэн чиглэлд тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллана.

1.4 “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг хэрэгжүүлж, сургалтын байгууллага ёс зүйн зөрчлөөс ангид байхыг эрхэмлэн багш, ажилтан бүр ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа чанд мөрдөнө.

1.5 НТБ-ын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгож хүн амд үйлчлэх хүрээ хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт хоёр: Сургалтын чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр:

2.1 Эх хэлээрээ зөв сайхан бичих чадварыг нэмэгдүүлэх.

2.2 Хоггүй цэвэр анги хамт олон болох.

2.3. Мэндлэх, хүндлэх ёсыг эрхэмлэх сурагч бүр, албан хаагч бүр өглөө, өдөр, орой мэндлэх ёсыг сахиж өөр хоорондоо мэндлэх

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бөмбөгөр сумын ЕБС нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор хийж гүйцэтгэлээ.

Бөмбөгөр сумын ЕБС нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Аcolous санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Тайлант онд тус байгууллагад хяналт байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Бөмбөгөр сумын ЕБС-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна..

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг үр дүнгийн тайлангийн зардлын 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2 хувиар буюу 11283.0 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн зардлын 2 хувиар буюу 17148.2 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс 5865.2 мянган төгрөгөөр их байгаа нь 4 дүгээр улиралд зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитыг гүйцэтгэх явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бөмбөгөр сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1157859.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 10574.6 мянган төгрөгөөр буюу 100.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мян.төг)			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	95,783.5	128,850.2	33,066.7
Авлага	10,000.0	9,950.0	(50.0)
Бараа материал	85,783.5	118,900.2	33,116.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,051,501.5	1,029,009.4	(22,492.1)
Үндсэн хөрөнгө	1,223,515.2	1,273,482.3	49,967.1
Хуримтлагдсан элэгдэл	(172,013.7)	(244,472.9)	(72,459.2)

Нийт хөрөнгө	1,147,285.1	1,157,859.6	10,574.6
Өр төлбөр	-	73.4	73.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,147,285.1	1,157,786.2	10,501.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,147,285.1	1,157,859.6	10,574.6

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Өмнөх онд “Элбата” ХХК-ийн дансанд 10 сая төгрөгийг урсгал засварын зардлаас шилжүүлж тайланд авлагаар тусгасан байсныг барагдуулсан бөгөөд оны эцэст төсөвт тодотгол хийж, “Санко Монголиа маркетинг” ХХК-д ухаалаг самбарын үнэнд 9950.0 мянган төгрөгийг шилжүүлж авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 118900.2 мянган төгрөг болж өмнөх оноос 33116.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас үнэ төлбөргүй сургалтын хэрэглэгдэхүүн, даам зэргийг өгсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны эцэст 1223515.2 мянган төгрөг байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 23740.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, бусад байгууллагаас 26226.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авсан ба үүнээс 10824.2 мянган төгрөгийн хөрөнгийг “Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас өгсөн хөрөнгө байна. Тайлант онд үндсэн хөрөнгө хасагдаагүй байна.

2020 оны 09 дүгээр сард хүүхэд харах чөлөөтэй байсан ажилтан С.Ундармаагийн кодыг буруу мэдээлснээс оны эцэст 73.4 мянган төгрөгийн өглөгтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 10574.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 1157786.2 мянган төгрөг болсон байна.

Бөмбөгөр сумын ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлэг өмнөх оноос 101903.6 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар, орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлын санхүүжилт 5543.6 мянган төгрөг буюу 13.9 хувиар өссөн бөгөөд, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого өмнөх оноос 400.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 1000.0 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

Нийт зардал өмнөх онд 684263.9 мянган төгрөг байсан бол тайлант оны зардал өмнөх оноос 77875.5 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар өсөж, 762139.5 мянган төгрөг гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 788144.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 25509.7 мянган төгрөгөөр		
Анхны батлагдсан төсөв	2020 оны 12 сард зохицуулалт хийсэн төсөв	нэмэгдүүлж, 813654.1 мянган төгрөгийг баталж, тайлант онд 7, 9, 12 дугаар сард төсөвт өөрчлөлт оруулж, оны эцэст 793281.9 мянган төгрөгөөр төсвийг баталжээ.
788144.4	793281.9	

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 745864.7 мянга, орон нутгийн төсвөөс 46417.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, үндсэн үйл ажиллагааны орлого оруулаагүй ба 50 орон тоотой үйл ажиллагаа явуулж, урсгал үйл ажиллагаанд 762139.5 мянган төгрөгийг зарцуулан, оны эцэст 30142.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 33288.6 мянган төгрөгийн орлого орсноос 10000.0 мянган төгрөг нь өмнөх оны аудитаар тогтоосон авлагыг буцаан төлсөн, 23288.6 мянган төгрөг нь аймгийн БСУГ-аас хуулийн дагуу олгох тэтгэмжийн санхүүжилт ба албан хаагчдад тэтгэмжийг бүрэн олгосон байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.

Хүснэгт 2. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	95	1	8 сард хөрөнгө зарцуулах шийдвэрийг хоцроож мэдээлсэн
Нийт		27	151	150	1	

Эх сурвалж: Бөмбөгөр сумын ЕБС-ийн шилэн данс

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитыг “Хонгор үр сад” ХХК-ийн аудитор Б.Бямбаа хийж гүйцэтгэн, 2 зөвлөмж өгснөөс НБББББ-ийг боловсруулах зөвлөмжийг хэрэгжүүлж, бүрэн боловсруулж дуусаагүй байгаа тул сумын Засаг даргын нэгтгэсэн тайлангаар нэгдсэн журмаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 34743.5 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт тайлагналын алдаатай холбоотой 11410.6 мянган төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалингийн цэстээр тайлант онд ажиллагсдад 554000.2 мянган төгрөгийн цалин олгосон байхад үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 542589.6 мянган төгрөгөөр буюу 11410.6 мянган төгрөгөөр дутуу илэрхийлж, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардалтай гүйлгэн бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд цалингийн зардлыг нэмэгдүүлж, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлыг бууруулж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 23332.9 мянган төгрөгийн 5 залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 16625.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 6707.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант онд кассын гүйлгээгээр 10041.8 мянган төгрөгийн гүйлгээ гарсан байхад нярав кассын тайлан гаргаагүй, кассаар дамжуулан зардлыг олгохдоо анхан шатны баримтын бүрдэл дутуу ба хөрөнгөд орлогод авахдаа худалдан авагч дээр "Төрийн сангийн кассын данс" гэж авсан, тооцоо нийлсэн акт, бараа материалын тайланг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй, бараа материалыг тайлангийн эхний үлдэгдлийг бөөн дүнгээр гаргасан, нярвын гаргасан тайлан ерөнхий дэвтрээс зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Кассын тайланг нөхөн гаргаж, худалдан авагчийн нэрээр бараа материалд орлого авах, нярвын тайлангийн эхний үлдэгдлийг хөрөнгө нэг бүрээр тайлагнаж, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын дагуу анхан шатны баримтыг хөтөлж, хяналт тавьж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Үндсэн хөрөнгөд бүртгэсэн 300.0 мянган төгрөгийн зургийн камер, 1568.4 мянган төгрөгийн сандал, 784.0 мянган төгрөгийн ширээний ашиглагдах жилийг 0 гэж бүртгэснээс үндсэн хөрөнгөд элэгдэл бодогдоогүй, 3931.6 мянган төгрөгийн номыг бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Бөөн дүнгээр авсан хөрөнгийг зарлагын падааныг үндэслэн хөрөнгө нэг бүрээр бүртгэж, үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг үнэн зөв оруулж, элэгдлийн зардлыг тайлант хугацаанд бүрэн тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6707.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Нягтлан бодогч нярвын гаргасан тайлангаар хөрөнгийн орлогод авдаггүй, бөөн дүнгээр орлогод авч байгааг анхаарах шаардлагатай.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

- 1.1. **Илрүүлэлт:** Төсвийн захирагч тушаал гаргаагүй байхад тайлант онд 6707.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан бөгөөд хөрөнгийг акталж устгасан баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй байна.
- 1.2. **Эрсдэл:** Тушаал шийдвэргүй хөрөнгийг акталж устгах, акталж устгасан хөрөнгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхгүй байх.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн гаргасан байгууллагын даргын тушаалаар хөрөнгийг акталж, устгал хийсэн баримт материалыг санхүүгийн анхан шатны баримтад хавсаргаж байх.
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

2. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

- 2.1. **Илрүүлэлт:** Сэтгүүл, утасны нэгж /модемийн сунгалт/ зэргийг бараа материалын орлогод авч зарлагадсан, эмийг эм боох материал дансанд нэр төрлөөр нь бүртгэдэггүй, бусад хангамжийн материалд бөөн дүнгээр бүртгэсэн байна. Тайлант онд худалдан авсан 83.6 мянган төгрөгийн эм, 250.0 мянган төгрөгийн ном, 2920.0 мянган төгрөгийн нүүрсийг нярав нэр төрлөөр нь орлогод авсан байхад нягтлан бодогч программд бөөн дүнгээр бүртгэсэн байна.
- 2.2. **Эрсдэл:** Хөрөнгийг нэр төрлөөр нь орлогод авахгүй байх, бараа материалд шууд зардлыг бүртгэх
- 2.3. **Өгсөн зөвлөмж:** Бараа материалд шууд зардлаар тайлагнах зардлыг бүртгэхийг зогсоох, няравын гаргасан материалын тайланд үндэслэн нягтлан бодогч санхүүгийн программд хөрөнгийг нэр төрлөөр нь бүртгэж байх.
- 2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

3. ТӨСВИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

- 3.1. **Илрүүлэлт:** Төсвийн захирагч оны эцэст эд хөрөнгийн тооллогын дүнг баталгаажуулсан тушаал гаргаагүй, цахимаар ирүүлсэн тооллогын бүртгэлийн дүн үндсэн хөрөнгөөс 85133.5 мянга, бараа материалаас 21518.2 мянган төгрөгийн зөрүүтэй байсан ба буруу файл ирүүлснээс дахин тулгалт хийж аудитад хүндрэл учруулсан.
- 3.2. **Эрсдэл:** Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баталгаажуулсан тушаалыг гаргаагүй байх, аудитад шаардлагатай баримт материалыг бүрэн ирүүлэхгүй байх.
- 3.3. **Өгсөн зөвлөмж:** Оны эцэст тооллогын комиссын тооллогын дүнд үндэслэн нягтлан бодогчийн тооцоо бодсон акттай танилцаж, байгууллагын дарга эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баталгаажуулсан тушаал гаргаж байх, нягтлан бодогч төрийн аудитын байгууллагаас шаардсан баримт материалыг цаг тухайд нь бүрэн хүлээлгэн өгөх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР



А.ЦЭЭНЯМ

Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2021.02.25

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.25	Аудитын нэр:	Бөмбөгөр сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/84/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгөд бүртгэсэн 300.0 мянган төгрөгийн зургийн камер, 1568.4 мянган төгрөгийн сандал, 784.0 мянган төгрөгийн ширээний ашиглагдах жилийг 0 гэж бүртгэснээс үндсэн хөрөнгөд элэгдэл бодогдоогүй, 3931.6 мянган төгрөгийн номыг бөөн дүнгээр бүртгэсэн.	6584.0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Насантогтох, Б.Ганболд
2	Кассын тайлан гаргаагүй, бараа материалын тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгээгүй.	10041.0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Насантогтох, Б.Ганболд
3	Санхүүгийн тайланд цалингийн зардлыг 11410.6 мянган төгрөгөөр дутуу, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлыг 11410.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	11410.6	Санхүүгийн тайланд залруулах	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Насантогтох, Б.Ганболд
4	Төсвийн захирагч оны эцэст эд хөрөнгийн тооллогын дүнг баталгаажуулсан тушаал гаргаагүй, цахимаар ирүүлсэн тооллогын бүртгэлийн дүн үндсэн хөрөнгөөс 85133.5 мянга, бараа материалаас 21518.2 мянган төгрөгийн зөрүүтэй байсан ба буруу файл ирүүлснээс дахин тулгалт хийж аудитад хүндрэл учруулсан.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Насантогтох, Б.Ганболд
5	Төсвийн захирагч тушаал гаргаагүй байхад 6707.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгасан бөгөөд хөрөнгийг акталж устгасан баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй.	6707.9	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Насантогтох, Б.Ганболд

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

А	1	2	3	4	5
6	Сэтгүүл, утасны нэгж /модемийн сунгалт/ зэргийг бараа материалын орлогод авч зарлагдсан, 2020 оны 10 дугаар сард авсан 83.6 мянган төгрөгийн эмийг бөөн дүнгээр орлогод авсан ба эмийг эм боох материал дансанд нэр төрлөөр нь бүртгэдэггүй, бусад хангамжийн материалд бөөн дүнгээр бүртгэсэн. Тайлант онд авсан 250.0 мянган төгрөгийн ном, 2920.0 мянган төгрөгийн нүүрсийг нярав нэр төрлөөр нь орлогод авсан байхад нягтлан бодогч программд бөөн дүнгээр орлогод авсан.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	Л.Насантогтох, Б.Ганболд
ДҮН		34743.5			

---oOo---